ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/117/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН 9 ЖИЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582  Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463  Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....12
3. Аудитын тайлан ....13
3.1 Ерөнхий зүйл....13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....13
3.4 Материаллаг байдал ....14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....15
3.8 Аудитын гол асуудал ....16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....16
3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт ....16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
4. Аудитын илрүүлэлт ....17
4.1 Залруулсан алдаа....17
4.2 Төлбөрийн акт ....17
4.3 Албан шаардлага ....17
4.4 Зөвлөмж....17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....18

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| НХМ | Нэг хэвийн маягт |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/125

танай ______ -ны № ______ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН 9 ЖИЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г.БОЛОРМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын 9 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянжаргалан сумын 9 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

19020394

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **61,099,556.47** | **61,055,736.50** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 61,099,556.47 | 61,055,736.50 |
| **351** | **Түүхий эд материал** | 140,000.00 | 100,094.00 |
| 35130 | Эм боох материал | 140,000.00 | 100,094.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 60,959,556.47 | 60,955,642.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,919,261.91 | 7,408,530.91 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,176,633.00 | 35,061,272.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 260,081.97 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,233,796.72 | 1,116,056.72 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,369,782.87 | 17,369,782.87 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,488,435,054.17** | **1,427,307,374.97** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,488,435,054.17 | 1,427,307,374.97 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,441,053,054.17 | 1,379,925,374.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,442,352,750.51 | 1,442,352,750.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -82,214,940.73 | -125,290,124.53 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 106,036,473.86 | 110,619,573.86 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -60,017,494.26 | -73,984,702.96 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,437,596.00 | 72,437,596.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -42,070,761.20 | -51,574,147.90 |
| 39217 | Ном | 4,529,429.99 | 5,364,429.99 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 47,382,000.00 | 47,382,000.00 |
| 39301 | Програм хангамж | 535,000.00 | 535,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -535,000.00 | -535,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 47,382,000.00 | 47,382,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,549,534,610.64** | **1,488,363,111.47** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,819,159.00** | **5,013,089.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,819,159.00 | 5,013,089.00 |
| **413** | **Өглөг** | 3,819,159.00 | 5,013,089.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 1,193,930.00 |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 3,819,159.00 | 3,819,159.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,545,715,451.64** | **1,483,350,022.47** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,545,715,451.64 | 1,483,350,022.47 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 476,568,508.51 | 476,568,508.51 |
| 51101 | Өмч: - төрийн | 476,568,508.51 | 476,568,508.51 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 562,476,725.94 | 500,111,296.77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 562,476,725.94 | 562,476,725.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -62,365,429.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 506,670,217.19 | 506,670,217.19 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,549,534,610.64** | **1,488,363,111.47** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **681,984,915.91** | **604,860,008.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **571,610,615.91** | **2,664,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 32,504,115.91 | 2,664,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 32,504,115.91 | 1,625,600.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 30,354,752.00 | 644,600.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 2,149,363.91 | 981,000.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 1,039,200.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 539,106,500.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 539,106,500.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **110,374,300.00** | **105,090,308.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 497,104,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 20,256,700.00 | 12,375,369.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,256,700.00 | 12,375,369.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 90,117,600.00 | 92,714,939.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 90,117,600.00 | 92,714,939.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **693,427,538.77** | **667,225,437.17** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **693,427,538.77** | **667,225,437.17** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 596,015,415.34 | 632,922,832.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 382,854,948.84 | 397,061,261.37 |
| 210101 | Үндсэн цалин | 258,100,510.98 | 278,913,954.73 |
| 210102 | Нэмэгдэл | 94,170,039.86 | 81,461,128.64 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,871,143.00 | 9,538,000.00 |
| 210104 | Урамшуулал | 20,713,255.00 | 27,148,178.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,639,246.72 | 51,554,083.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,601,551.00 | 35,926,321.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,823,731.00 | 3,969,199.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,058,986.00 | 3,175,359.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 704,413.87 | 764,776.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,450,564.85 | 7,718,425.82 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 89,911,976.00 | 91,714,939.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,584,468.00 | 2,895,139.00 |
| 210302 | Түлш, халаалт | 87,127,508.00 | 88,652,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 167,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,691,490.00 | 7,687,422.97 |
| 210401 | Бичиг хэрэг | 257,820.00 | 555,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 588,070.00 | 758,851.97 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 725,000.00 | 360,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 50,000.00 | 30,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,070,600.00 | 685,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 5,297,271.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 10,765,499.97 | 13,780,706.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 140,000.00 | 228,906.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,625,499.97 | 13,511,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 40,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 176,000.00 | 188,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 176,000.00 | 188,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,107,540.00 | 00.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,107,540.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 60,868,713.81 | 69,936,419.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,500.00 | 1,069,990.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 738,800.00 | 2,320,650.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 59,984,413.81 | 66,545,779.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 97,412,123.43 | 34,302,604.94 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 20,413,319.99 | 25,892,300.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,932,619.99 | 17,006,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,560,700.00 | 7,965,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,000.00 | 920,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 76,998,803.44 | 8,410,304.94 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 76,998,803.44 | 8,410,304.94 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-11,442,622.86** | **-62,365,429.17** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-11,442,622.86** | **-62,365,429.17** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **476,568,508.51** | **506,670,217.19** | **562,476,725.94** | 1,545,715,451.64 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **476,568,508.51** | **506,670,217.19** | **562,476,725.94** | 1,545,715,451.64 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -62,365,429.17 | -62,365,429.17 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **476,568,508.51** | **506,670,217.19** | **500,111,296.77** | 1,483,350,022.47 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **649,480,800.00** | **603,234,408.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **629,224,100.00** | **93,754,139.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 1,039,200.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 1,039,200.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 629,224,100.00 | 92,714,939.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 539,106,500.00 | 00.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 90,117,600.00 | 92,714,939.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **20,256,700.00** | **509,480,269.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 497,104,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 20,256,700.00 | 12,375,369.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,256,700.00 | 12,375,369.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **649,480,800.00** | **598,460,908.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **649,480,800.00** | **598,460,908.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **549,405,186.56** | **566,753,203.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 384,296,361.99 | 397,259,440.80 |
| 210101 | Үндсэн цалин | 259,303,924.13 | 273,166,303.59 |
| 210102 | Нэмэгдэл | 94,170,039.86 | 85,403,811.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,109,143.00 | 11,805,200.21 |
| 210104 | Урамшуулал | 20,713,255.00 | 26,884,126.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **46,445,287.57** | **51,355,904.26** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,814,014.15 | 35,871,702.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,907,194.00 | 3,897,344.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,135,442.00 | 3,117,995.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 777,975.00 | 770,105.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,810,662.42 | 7,698,756.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,092,817.00** | **91,714,939.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,584,468.00 | 2,895,139.00 |
| 210302 | Түлш, халаалт | 83,308,349.00 | 88,652,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 167,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,839,170.00** | **2,864,139.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 302,000.00 | 459,569.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 649,370.00 | 498,770.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 650,000.00 | 525,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 66,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 164,400.00 | 160,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,007,400.00 | 1,220,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **11,239,060.00** | **17,804,730.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 280,000.00 | 459,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,739,060.00 | 14,743,530.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,220,000.00 | 2,602,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **176,000.00** | **223,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 176,000.00 | 223,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,169,990.00** | **00.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,169,990.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,146,500.00** | **4,531,050.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,696,000.00 | 1,375,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,450,500.00 | 3,155,850.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **100,075,613.44** | **31,707,704.94** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,076,810.00 | 23,297,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 9,596,110.00 | 14,411,100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,560,700.00 | 7,965,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,000.00 | 920,500.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 76,998,803.44 | 8,410,304.94 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **4,773,500.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **4,773,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **4,773,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 4,773,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-4,773,500.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **589,819,839.00** | **581,409,534.06** | **8,410,304.94** | **98.6** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **589,819,839.00** | **581,409,534.06** | **8,410,304.94** | **98.6** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **574,488,239.00** | **566,077,934.06** | **8,410,304.94** | **98.5** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **404,545,000.00** | **397,259,440.80** | **7,285,559.20** | **98.2** |
| Үндсэн цалин | 272,263,100.00 | 273,166,303.59 | (903,203.59) | 100.3 |
| Нэмэгдэл | 92,329,500.00 | 85,403,811.00 | 6,925,689.00 | 92.5 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 13,068,000.00 | 11,805,200.21 | 1,262,799.79 | 90.3 |
| Урамшуулал | 26,884,400.00 | 26,884,126.00 | 274.00 | 100.0 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **54,613,500.00** | **51,355,904.26** | **3,257,595.74** | **94.0** |
| Тэтгэврийн даатгал | 38,432,300.00 | 35,871,702.14 | 2,560,597.86 | 93.3 |
| Тэтгэмжийн даатгал | 4,046,300.00 | 3,897,344.87 | 148,955.13 | 96.3 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,236,900.00 | 3,117,995.35 | 118,904.65 | 96.3 |
| Ажилгүйдлийн даатгал | 809,900.00 | 770,105.22 | 39,794.78 | 95.1 |
| Эрүүл мэндийн даатгал | 8,088,100.00 | 7,698,756.68 | 389,343.32 | 95.2 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **91,714,939.00** | **91,714,939.00** | **-** | **100.0** |
| Гэрэл, цахилгаан | 5,805,600.00 | 2,895,139.00 | 2,910,461.00 | 49.9 |
| Түлш, халаалт | 85,709,339.00 | 88,652,800.00 | (2,943,461.00) | 103.4 |
| Цэвэр, бохир ус | 200,000.00 | 167,000.00 | 33,000.00 | 83.5 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **3,745,000.00** | **3,589,570.00** | **155,430.00** | **95.8** |
| Бичиг хэрэг | 350,000.00 | 350,000.00 | - | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 500,000.00 | 498,770.00 | 1,230.00 | 99.8 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 | 525,000.00 | (25,000.00) | 105.0 |
| Ном, хэвлэл | 235,000.00 | 235,000.00 | - | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 160,000.00 | 160,000.00 | - | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,000,000.00 | 1,820,800.00 | 179,200.00 | 91.0 |
| **Нормативт зардал** | **15,479,800.00** | **17,804,730.00** | **(2,324,930.00)** | **115.0** |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,000.00 | 459,000.00 | 41,000.00 | 91.8 |
| Хоол, хүнс | 12,179,800.00 | 14,743,530.00 | (2,563,730.00) | 121.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,800,000.00 | 2,602,200.00 | 197,800.00 | 92.9 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** | **-** | **100.0** |
| Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |
| **Томилолт, зочны зардал** | 223,000.00 | 223,000.00 | - | 100.0 |
| Дотоод албан томилолт | 223,000.00 | 223,000.00 | - | 100.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,167,000.00 | 3,130,350.00 | 36,650.00 | 98.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 | 1,375,200.00 | 24,800.00 | 98.2 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,767,000.00 | 1,755,150.00 | 11,850.00 | 99.3 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15,331,600.00 | 15,331,600.00 | - | 100.0 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 15,331,600.00 | 15,331,600.00 | - | 100.0 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,411,100.00 | 14,411,100.00 | - | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 920,500.00 | 920,500.00 | - | 100.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **589,819,839.00** | **581,409,534.06** | **8,410,304.94** | **98.6** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **589,819,839.00** | **581,409,534.06** | **8,410,304.94** | **98.6** |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 497,104,900.00 | 488,912,122.06 | 8,192,777.94 | 98.4 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 92,714,939.00 | 92,497,412.00 | 217,527.00 | 99.8 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | - | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | - | |
| **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | - | - | |
| **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | - | - | - | |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 34.00 | 33.00 | 1.00 | 97.1 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 18.00 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 15.00 | 14.00 | 1.00 | 93.3 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **13,414,569.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **13,414,569.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 5,448,769.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | | 109,569.00 |
| Бичиг хэрэг | | 109,569.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 5,339,200.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 5,339,200.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 7,965,800.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | | 7,965,800.00 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 7,965,800.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 12,375,369.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 12,375,369.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 12,375,369.00 |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын 9 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, тооллогын бүртгэл, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын 9 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын 9 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 693,427.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,934.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,854.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн. 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 663,160.7 мянган төгрөгийн 0.7 хувиар буюу 4,642.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянжаргалан сумын 9 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд Тусгай зориулалтын шилжүүлгээс 589,819.8 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 12,375.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар 12,375.4 мянган төгрөг зарцуулсан байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 4,583.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 835.0 мянган төгрөгийн номын фонд, нийт 5,418.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,773.5 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 644.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 981.0 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 39,575.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 40,600.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

***Авлага, өглөгийн талаар***:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагагүй, 5,013.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна.

Бараа материал 61,055.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,427,307.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 61,099.6 | 61,055.7 | (43.8) |
| Үндсэн хөрөнгө | 1,488,435.0 | 1,427,307.4 | (61,127.7) |
| Нийт хөрөнгө | **1,549,534.6** | **1,488,363.1** | (61,171.5) |
| Өглөг | 3,819.2 | 5,013.0 | 1,193.9 |
| ЗГ-н оруулсан капитал | 476,568.5 | 476,568.5 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 562,476.7 | 500,111.3 | (62,365.4) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | **1,549,534.6** | **1,488,363.1** | (61,171.5) |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө данс тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 61,171.5 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 603,692.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 93,000.0 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 696,692.3 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 106,872.5 мянган төгрөгөөр бууруулан 589,819.8 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 497,104.9 мянга, орон нутгийн төсвөөс 92,714.94 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 581,409.5 мянган төгрөгийг зарцуулж, 8,410.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 581,409.5 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас 12,375.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 7,965.8 мянган, хичээл үйлдвэрлэлийн дадлага, бичиг хэргийн зардалд 5,339.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 4,583.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 835.0 мянган төгрөгийн номын фонд, нийт 5,418.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж,

тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 4,773.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 644.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Төсвийг бүлэг дотор зардлыг хэтрүүлэн зарцуулж байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант хугацааны эцэст 4,773.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, хөрөнгө худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал, үдийн хоол, дотуур байрны хүнсний материал, ахуй бараа материалыг зөвхөн нэг газраас худалдан авалт хийж байгааг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23,864.5 мянган төгрөгийн 6 алдаа зөрчилд 14,078.1 мянган төгрөгийн 1 зөрчилд залруулга хийж, 4,773.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 5,013.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн элэгдэл бодоогүй 14,078.1 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийг бодуулж элэгдлийн зардал, хуримтлагдсан үр дүнд тус тус залруулга хийлгэв.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.3 Албан шаардлага

Тайлант хугацааны эцэст 4,773.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн тул албан шаардлага өгөх.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 24,248.1 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох“ тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. ***Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Үндсэн хөрөнгийн тооллогын баримт ирүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх бариүч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**3. *Өглөгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Байгууллагад өгөх 5,013.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “үнэн зөв бай”х гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**4. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.”тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль | 6 | 23,864.5 | 1 | 14,078.1 | | | 1 | 4,773.5 | 4 | 5,013.0 |
| | ДҮН | 6 | 23,864.5 | 1 | 14,078.1 | | | 1 | 4,773.5 | 4 | 5,013.0 |